# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ – 2024 ОН

ЗОХИЦУУЛАЛТТАЙ САЛБАРЫН НЭГДСЭН СУДАЛГАА

(ДААТГАГЧ, ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН КОМПАНИ, ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ)

**Гүйцэтгэсэн:**

А.Авир, дарга
Л.Мөнхзаяа, ахлах референт
Ж.Лхагвамядаг, мэргэжилтэн
Б.Арьяаманал, мэргэжилтэн

# ЗОХИЦУУЛАЛТТАЙ САЛБАРЫН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ - 2024 ОН

## 1. ҮЙЛ ЯВЦЫН ӨРНӨЛ

**2006 он**

Монгол Улсын Их хурлаас "Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм"-ийг баталж, компанийн засаглалын зарчмыг нэвтрүүлэх, боловсронгуй болгох бүрэн эрхийг тус Хороонд олгов.

**2007 он**

"Монгол компанийн засаглалын кодекс"-ийг Хороо анх удаа батлав.

**2014 он**

"Компанийн засаглалын кодекс"-т нэмэлт, өөрчлөлт оров.

**2022.03.23**

Хорооны 145 дугаар тогтоолоор "Компанийн засаглалын кодекс"-ийн шинэчилсэн найруулга батлагдлаа. Шинэчилсэн кодексийн хавсралтаар олон улсад түгээмэл ашиглагддаг "Хэрэгжүүл, эсвэл тайлбарла" гэсэн зарчмаар үнэлгээний аргачлал бүхий тайлангийн маягт болон компанийн дотооддоо баталж, мөрдөх бодлогын баримт бичиг, дүрэм, журмын зааврын үлгэрчилсэн загваруудыг батлав.

**2022.04.15**

Кодекс "Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэл"-д бүртгэгдэж, эрх зүйн мэдээллийн www.legalinfo.mn нэгдсэн системд байршсанаар хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн ба нээлттэй хувьцаат компаниудаас гадна даатгагч, итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч банк бус санхүүгийн байгууллага (ББСБ) болон хөрөнгө оруулалтын менежментийн компани (ХОМК)-ууд дагаж мөрдөх үүргийг хүлээв.

**2022.04.20**

Хорооны зохицуулалтын 3 салбарын нийт 116 зохицуулалттай этгээдийн ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх удирдлагуудыг оролцуулан кодексийн хэрэгжилтийн үнэлгээг хэрхэн тайлагнах талаар сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулав.

**2022.05.16**

Зохицуулалттай этгээд (даатгагч, ББСБ, ХОМК)-ийн кодексийн хэрэгжилтийг үнэлэх ажлыг эхлүүлэв.

**2022.06.22**

Хорооны даргын 2022 оны 336 дугаар тушаалаар "Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын удирдамж"-ийг баталж, компанийн засаглалын зарчмуудыг нэвтрүүлэх нэгдсэн зохион байгуулалт, зах зээлд оролцогч талуудын баримтлах зарчим, чиг үүргийг тодорхойлов.

**2022.12.30**

Хорооны зохицуулалтын 3 салбарын нийт 116 зохицуулалттай этгээд (даатгагч, ББСБ, ХОМК)-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлэн тайлангийн хариугаар заавар зөвлөмж, эсхүл хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг нь тооцон салбар тус бүрийн зэрэглэлийг тогтоож, нийтэд мэдээлэв. Үнэлгээг хянан баталгаажуулахад, 2022 оны 8 дугаар сарын байдлаар кодексийн хэрэгжилтийн анхны буюу нөхцөл байдлын үнэлгээ 55.3 хувийн гүйцэтгэлтэй байсан бол Хорооноос үнэлгээний тайлангийн хариугаар компани тус бүрт зөвлөмж, чиглэл, хугацаатай үүрэг даалгавар өгч, мөн оны 12 дугаар сард биелэлтийг нь тооцсон давтан үнэлгээгээр зохицуулалттай 3 салбарын кодексийн хэрэгжилт дунджаар 16.4 хувиар өсөв.

**2023.06.30**

Хорооны зохицуулалттай нийт 124 этгээд (даатгагч, ББСБ, ХОМК)-ийн үнэлгээг хийж, компани тус бүрд хугацаатай үүрэг даалгавар өгөв.

**2023.12.28**

Хорооны зохицуулалттай 124 этгээд (даатгагч, ББСБ, ХОМК)-ээс тайлангаа давтан ирүүлсэн 81 компанийн тайланг хянан баталгаажуулахад 2023 оны эцсийн байдлаар дундаж үнэлгээ 2022 оныхоос 26.4 хувиар дээшилсэн ахиц дэвшлийг үзүүлэв.

**2024.10.15**

Хорооны зохицуулалттай виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч (ВХҮҮ) 12 компанийн кодексийн хэрэгжилтийг үнэлэх ажлыг эхлүүлэв.

**2025.01.20**

Хорооны зохицуулалттай 140 этгээд (даатгагч, ББСБ, ХОМК)-ийн 2024 оны жилийн эцсийн тайлангаа ирүүлсэн 95 компанийн давтан үнэлгээг хянан баталгаажуулахад, кодексийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ 30.2 хувиар өсөв.

## 2. СУДАЛГААНЫ ТАЛААР

Компанийн засаглалыг нэвтрүүлэх нь бизнесийн үйл ажиллагааны урт хугацааны өгөөжийг хангах төдийгүй хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн хүлээлтэд суурилсан шударга, нээлттэй зах зээлийн орчин бүрдэхэд эергээр нөлөөлдөг тул нийгэмд ач холбогдолтой энэ сэдвийг онцгойлон анхаарч, тогтмол хөгжүүлэх шаардлагатай.

Олон улсын практикийн дагуу компанийн засаглалын чанар, кодексийн хэрэгжилтийг үнэлэхдээ эрсдэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн зэрэглэл тогтоох аргыг ашиглав.

Компанийн засаглалын зэрэглэл нь тухайн компанийн үйл ажиллагаанд эрсдэлийн дүн шинжилгээ хийх мэдээлэл болж өгснөөр хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрсдэлгүй шийдвэр гаргалтад эергээр нөлөөлнө.

## 3. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ

- Кодексийн хэрэгжилтийг аргачлалын дагуу үнэлж нэгдсэн тайлан боловсруулах;
- компанийн засаглалын хандлага, учирч болох эрсдэлийг тодорхойлох;

- хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгч эрсдэлийн үнэлгээ хийж, шийдвэр гаргах засаглалын үзүүлэлтийг бий болгох;
- засаглалаар тэргүүлэгчдийг тодруулах, компанийн засаглалын зэрэглэл тогтоох;
- зохицуулалттай этгээд өөрийн засаглалыг салбартаа харьцуулах, сайжруулахад чиг баримжаа болох компанийн засаглалын жишгийг тодорхойлох;
- хууль тогтоомж болон компанийн баталсан дотооддоо дагаж мөрдөх дүрэм, журмын эрх зүйн орчныг оновчтой болгож, сайжруулах;
- хугацааны цуваа хэлбэрээр статистик мэдээллийг үүсгэх.

## 4. АРГАЧЛАЛ

Судалгаа нь “Компанийн засаглалын кодекс”-ийн 36 зүйлийн хэрэгжилтийн асуумжаар 152 зохицуулалттай этгээд (даатгагч, ББСБ, ХОМК, ВХҮҮ)-ийн анхны үнэлгээ, 104 компанийн давтан үнэлгээний тайлангууд болон Хорооноос хэрэгжүүлсэн судалгааны үр дүнд суурилсан.

### 4.1. СУДАЛГААНЫ ГОЛЛОХ СЭДЭВ:

**а. ТУЗ болон түүний дэргэдэх хороодын үйл ажиллагаа, бүтэц, бүрэлдэхүүн.**

**б. дотоод эрх зүйн зохицуулалтын ил тод байдал (цахим хуудасны шинэчлэл):**

- бодлогын баримт бичиг;
- ёс зүйн дүрэм;
- компанийн дүрэм, дотоод үйл ажиллагааны журам;
- мэдээллийн ил тод байдал, тайлагнал, комплайнсын хяналт, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны журам, заавар;
- компанийн эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан сургалтын хөтөлбөр.

**в. хамгийн сайн болон муу хэрэгжсэн засаглалын үзүүлэлтүүд.**

### 4.2. СУДАЛГААНД ХАМРАГДАГСАД:

Кодексийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн зохицуулалттай этгээд (Даатгагч, ББСБ, ХОМК, ВХҮҮ).

а. Компанийн засаглал, комплайнсын хэлтсээс нийт 152 зохицуулалттай этгээд (даатгагч, ББСБ, ХОМК, ВХҮҮ)-ийн анхны үнэлгээг хийж, тайлангийн хариугаар хугацаатай үүрэг бүхий албан тоот хүргүүлснээр нийт 104 компанийн давтан зайны үнэлгээг кодексийн хавсралт болох асуулгын маягтын дагуу гүйцэтгэж, оноогоор үнэлэв.

б. Компаниудын ирүүлсэн зайны үнэлгээг хавсаргасан нотлох баримтад үндэслэн үнэлгээний хяналтын оноо болон хувиар нэгдсэн дүнг тооцов.

в. Үнэлгээний нэгдсэн дүнг үндэслэн компани тус бүрд тухайлсан зөвлөмж, чиглэл хүргүүлэн тэдгээрийн биелэлтээр зайны үнэлгээний ахиц дэвшлийг тодорхойлов.

Компанийн үнэлгээний нэгдсэн дүн нь тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, бүртгэл хийхтэй холбоотойгоор Хорооноос холбогдох шийдвэр гаргах, компанийн засаглалын тухайн үеийн нөхцөл байдлыг тодорхойлох болон эрх зүйн орчныг боловсронгуй, оновчтой болгох чиглэлд дүн шинжилгээ хийх, мөн компанийн засаглалын зэрэглэлийн нэгдсэн судалгааг гарган нийтлэх, мэдээллийн зорилгоор ашиглагдана.

## 5. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

*ДҮРСЛЭЛ 1. “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЗАЙНЫ ҮНЭЛГЭЭНД СУУРИЛСАН ХУГАЦААТАЙ ЧИГЛЭЛ, ҮҮРГИЙН ДАГУУ ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ:*




*Шигтгээ 1:*

*Давтан үнэлгээгээр нийт 95 зохицуулалттай этгээд (Даатгагч, ББСБ, ХОМК)-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээ дунджаар 30.2 хувиар өсөв.*

*Шигтгээ 2:*

*Даатгагч 33.2, ББСБ 34.2, ХОМК 23.3 хувиар тус тус өсөлтийг харуулав.*




*Шигтгээ 3:*

*Нийт виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч 9 компанийн кодексийн хэрэгжилтийн давтан үнэлгээ 6.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.*

*ДҮРСЛЭЛ 2. "КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС"-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ БОЛОН ЗОХИЦУУЛАЛТЫН САЛБАРЫН ХАРИЛЦАН ХАМААРАЛ:*




*ДҮРСЛЭЛ 3. ЦАХИМ ХУУДСАНДАА ИЛ БОЛГОСОН МЭДЭЭЛЭЛ:*




*ДҮРСЛЭЛ 4. "КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС"-ИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛД ХИЙГДСЭН ТОХИРУУЛГА БУЮУ ШААРДЛАГА:*



# 6. ДААТГАГЧИЙН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ

*ДҮРСЛЭЛ 5. КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН АХИЦ ДЭВШИЛ:*




*Шигтгээ 4:*

*Нийт 13 даатгагчийн кодексийн хэрэгжилтийн давтан үнэлгээ 33.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.*

*ДҮРСЛЭЛ 6. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН:*




*Шигтгээ 5:*

*Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн 5-9 гишүүнтэй, үүнээс 31.1% нь хараат бус гишүүд байна.*

*Шигтгээ 6:*

*Нийт төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 36.3 хувийг эмэгтэй гишүүд эзэлж байна.*

*ДҮРСЛЭЛ 7. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:*




*ДҮРСЛЭЛ 8. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНААР АЖИЛЛАСАН АЖЛЫН ТУРШЛАГА (Жилээр):*




*ДҮРСЛЭЛ 9. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:*



*ДҮРСЛЭЛ 10. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН НАСЖИЛТ БА ЭЗЭМШСЭН МЭРГЭЖИЛ:*




*ДҮРСЛЭЛ 11. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД:*




*Шигтгээ 7:*

*Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод тус бүр дунджаар* **3-5** *гишүүнтэй.*

*ДҮРСЛЭЛ 12. ЦАХИМ ХУУДСАНД БАЙРШУУЛСАН ДОТООД ДҮРЭМ, ЖУРМЫН НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДЛЫН МЭДЭЭЛЭЛ:*




*Шигтгээ 8:*

*2024 оны байдлаар* **95.0%** *нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаа өөрийн цахим хуудсандаа байршуулсан.*

*Шигтгээ 9:*

*Тайлант хугацаанд* **75.0%** *нь дотоод дүрэм, журмаа нээлттэй болгосон.*

*ДҮРСЛЭЛ 13. САЙН БОЛОН МУУ ХЭРЭГЖСЭН КОДЕКСИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД:*



## 6.1. “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭГЭЭР БАЙР ЭЗЛҮҮЛСЭН ЗЭРЭГЛЭЛ* (Давтан үнэлгээ ирүүлсэн компанийг ногооноор тодруулав)

| № | Компанийн нэрс | Үнэлгээ | Байр |
|---|---|---|---|
| 1 | "АГУЛА ДААТГАЛ" ХХК | 97.2% | 1 |
| 2 | "МИГ ДААТГАЛ" ХХК | 97.2% | |
| 3 | "ПРАКТИКАЛ ДААТГАЛ" ХХК | 95.8% | 2 |
| 4 | "УЛААНБААТАР ХОТЫН ДААТГАЛ" ХХК | 94.4% | 3 |
| 5 | "ХААН ДААТГАЛ" ХХК | 94.4% | |
| 6 | "АМАР ДААТГАЛ" ХХК | 93.1% | 4 |
| 7 | "ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ" ХК | 91.7% | 5 |
| 8 | "ГАН ЗАМ ДААТГАЛ" ХХК | 90.3% | 6 |
| 9 | "НОМИН ДААТГАЛ" ХХК | 87.5% | 7 |
| 10 | "МАНДАЛ ЛАЙФ ДААТГАЛ" ХХК | 87.5% | |
| 11 | "МӨНХ ДААТГАЛ" ХХК | 87.5% | |
| 12 | "ИНШҮРКО ДААТГАЛ" ХХК | 81.9% | 8 |
| 13 | "МОНРЕ ДААТГАЛ" ХХК | 80.6% | 9 |
| 14 | "НЭЙШНЛ ЛАЙФ ДААТГАЛ" ХХК | 80.6% | |

## 7. ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ

*ДҮРСЛЭЛ 14. КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН АХИЦ ДЭВШИЛ:*




*Шигтгээ 10:*

*Нийт итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч 64 ББСБ-ын кодексийн хэрэгжилтийн давтан үнэлгээ 34.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.*

* “Ард даатгал” ХК, “Бодь даатгал” ХК, “Мандал даатгал” ХК, “Монгол даатгал”, “Тэнгэр даатгал” ХК-уудын хэрэгжилтийг “Монголын хөрөнгийн бирж” ХК-д бүртгэлтэй нээлттэй хувьцаат компанийн кодексийн үнэлгээний тайланд тусгасан болно.

*ДҮРСЛЭЛ 15. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН:*




*Шигтгээ 11:*

*Төлөөлөн удирдах зөвлөл нь 3-9 хүний бүрэлдэхүүнтэйгээс 24.8% нь хараат бус гишүүд байна.*

*Шигтгээ 12:*

*Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний 34.7% нь эмэгтэй.*

*ДҮРСЛЭЛ 16. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:*




*ДҮРСЛЭЛ 17. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНААР АЖИЛЛАСАН АЖЛЫН ТУРШЛАГА (Жилээр):*



*ДҮРСЛЭЛ 18. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:*




*ДҮРСЛЭЛ 19. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН НАСЖИЛТ БА ЭЗЭМШСЭН МЭРГЭЖИЛ:*




*ДҮРСЛЭЛ 20. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД:*




*Шигтгээ 13:*

*Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод тус бүр дунджаар 3-5 гишүүнтэй.*

*ДҮРСЛЭЛ 21. ЦАХИМ ХУУДСАНД БАЙРШУУЛСАН ДОТООД ДҮРЭМ, ЖУРМЫН НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДЛЫН МЭДЭЭЛЭЛ:*




*Шигтгээ 14:*

*2024 оны байдлаар 43.0% нь компанийн дүрмээ өөрийн цахим хуудсандаа байршуулсан.*

*Шигтгээ 15:*

*Тайлант хугацаанд 75.0% нь дотоод дүрэм, журмаа нээлттэй болгосон.*

*ДҮРСЛЭЛ 22. САЙН БОЛОН МУУ ХЭРЭГЖСЭН КОДЕКСИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД:*



## 7.1. “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭГЭЭР БАЙР ЭЗЛҮҮЛСЭН ЗЭРЭГЛЭЛ† (Давтан үнэлгээ ирүүлсэн компанийг ногооноор тодруулав)

| № | Компанийн нэрс | Үнэлгээ | Байр |
|---|---|---|---|
| 1 | "АБТС ББСБ" ХХК | 98.6% | 1 |
| 2 | "БИЗНЕС-ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ" ХХК | 98.6% | |
| 3 | "БУЛЛ КАПИТАЛ ББСБ" ХХК | 98.6% | |
| 4 | "СЭНД ЭМ ЭН ББСБ" ХХК | 98.6% | |
| 5 | "ФИНРҮҮТ-ИНВЕСТМЕНТ ББСБ" ХХК | 98.6% | |
| 6 | "ЕСӨН ШИЖИР ИНВЕСТ ББСБ" ХХК | 97.2% | 2 |
| 7 | "ИНВЕСКОР ХЭТЭВЧ ББСБ" ХХК | 97.2% | |
| 8 | "НЭТ КАПИТАЛ ФИНАНС КОРПОРАЦИ ББСБ" ХХК | 97.2% | |
| 9 | "ОМНИ КАПИТАЛ ББСБ" ХХК | 97.2% | |
| 10 | "ХАТАН СУУДАЛ ИНВЕСТ ББСБ" ХХК | 97.2% | |
| 11 | "ТАВАН БОГД ФИНАНС ББСБ" ХХК | 97.2% | |
| 12 | "ПРОГРЕСС КАПИТАЛ ББСБ" ХХК | 95.8% | 3 |
| 13 | "МЭЙН СТРИТ ФИНАНС ББСБ" ХХК | 95.8% | |
| 14 | "АШИД КАПИТАЛ ББСБ" ХХК | 94.4% | 4 |
| 15 | "КЛОВЕР ББСБ" ХХК | 94.4% | |
| 16 | "МОБИФИНАНС ББСБ" ХХК | 94.4% | |
| 17 | "НӨМӨР КРЕДИТ ББСБ" ХХК | 94.4% | |
| 18 | "НЬЮФОНД ББСБ" ХХК | 94.4% | |
| 19 | "ҮЙЗЭН-ИВЭЭЛТ ББСБ" ХХК | 94.4% | |
| 20 | "ИХ ИРЭЭДҮЙ КАПИТАЛ ББСБ" ХХК | 93.1% | 5 |
| 21 | "ХАС ХААН ББСБ" ХХК | 93.1% | |
| 22 | "СОНО ФИНТЕК ББСБ" ХХК | 93.1% | |
| 23 | "ЗӨГИЙ САНХҮҮГИЙН ГРУПП ББСБ" ХХК | 91.7% | 6 |
| 24 | "СИ И СИ ИНВЕСТМЕНТ ББСБ" ХХК | 91.7% | |
| 25 | "ФРАНКФУРТ КАПИТАЛ ББСБ" ХХК | 91.7% | |
| 26 | "ГЭРЭЛ ФИНАНС ББСБ" ХХК | 90.3% | 7 |
| 27 | "ЖЭТФИНАНС ББСБ" ХХК | 90.3% | |
| 28 | "ЗЭЭЛ ЭМ ЭН ПЛАТФОРМ ББСБ" ХХК | 90.3% | |
| 29 | "КИНГДОМ ИНВЕСТ ББСБ" ХХК | 90.3% | |
| 30 | "СЭКЮР ФИНАНС ББСБ" ХХК | 90.3% | |
| 31 | "ФИНКО КАПИТАЛ ББСБ" ХХК | 90.3% | |
| 32 | "БҮРЭНФИНАНС ББСБ" ХХК | 88.9% | 8 |
| 33 | "ДОТНО ФИНАНС ББСБ" ХХК | 88.9% | |
| 34 | "МАНДАЛ ДИЖИТАЛ КРЕДИТ ББСБ" ХХК | 88.9% | |
| 35 | "ТРАСТ ФИНАНС ББСБ" ХХК | 88.9% | |
| 36 | "ХӨТӨЛТНОМГОН ББСБ" ХХК | 88.9% | |
| 37 | "МОНГОЛЖИН ВЕНЧУР КАПИТАЛ ББСБ" ХХК | 87.5% | 9 |
| 38 | "МӨНХ ОРШИХ КАПИТАЛ ББСБ" ХХК | 87.5% | |
| 39 | "ХӨГЖИЛ ФИНАНС ББСБ" ХХК | 87.5% | |
| 40 | "БСБ ФИНАНС ББСБ" ХХК | 86.1% | 10 |
| 41 | "ГОЛДЕН ХИЛЛ ПАРТНЕРС ББСБ" ХХК | 86.1% | |
| 42 | "ЭН ВИ СИ ББСБ" ХХК | 86.1% | |
| 43 | "НОРБУ ББСБ" ХХК | 84.7% | 11 |
| 44 | "ЭКО КРЕДИТ ББСБ" ХХК | 84.7% | |
| 45 | "АЛТАН ЗООС КАПИТАЛ ББСБ" ХХК | 83.3% | 12 |
| 46 | "БИЧИЛ ГЛОБУС ФИНАНС ББСБ" ХХК | 83.3% | |
| 47 | "БЭРС ФИНАНС ББСБ" ХХК | 83.3% | |
| 48 | "ДИ ЭМ ФИНАНС ББСБ" ХХК | 83.3% | |
| 49 | "ЖИ ЭС БИ КАПИТАЛ ББСБ" ХХК | 83.3% | |
| 50 | "МОНГОЛИАНМОРТГЭЙЖ ФАНД ББСБ" ХХК | 83.3% | |

† “Ард кредит ББСБ” ХК, “Инвескор ББСБ” ХК, “Лэндмн ББСБ” ХК, “Сэндли ББСБ” ХК, “Тандэм инвест ББСБ” ХК-уудын хэрэгжилтийг “Монголын хөрөнгийн бирж” ХК-д бүртгэлтэй нээлттэй хувьцаат компанийн кодексийн үнэлгээний тайланд тусгасан болно.

| | | | |
|---|---|---|---|
| 51 | "АЛЛИАНС КАПИТАЛ ББСБ" ХХК | 81.9% | 13 |
| 52 | "АШИД ГОЛОМТ ББСБ" ХХК | 81.9% | |
| 53 | "ДАРЬ ФИНАНС ББСБ" ХХК | 81.9% | |
| 54 | "МИКРОКРЕДИТ ББСБ" ХХК | 81.9% | |
| 55 | "ҮНЭТ КРЕДИТ ББСБ" ХХК | 81.9% | |
| 56 | "АНДУУД ФИНАНС ББСБ" ХХК | 80.6% | 14 |
| 57 | "ДЕВЕЛОПИНГ ЭНТЕРПРЕНЮРИАЛ МОНГОЛИА ББСБ" ХХК | 80.6% | |
| 58 | "МАГНА ПРОФИТ ЭНД ИНВЕСТМЕНТ ББСБ" ХХК | 80.6% | |
| 59 | "ЭКСИМ КАПИТАЛ ББСБ" ХХК | 80.6% | |
| 60 | "ЭНХФАЙНАНС ББСБ" ХХК | 77.8% | 15 |
| 61 | "ИХ ЭРИН КАПИТАЛ ББСБ" ХХК | 76.4% | 16 |
| 62 | "ОЧИР УНДРАА ОМЗ ББСБ" ХХК | 76.4% | |
| 63 | "ШИЙДЭЛ ФИНАНС ББСБ" ХХК | 76.4% | |
| 64 | "КРЕДИТЕХ СТМ ББСБ" ХХК | 75.0% | 17 |
| 65 | "ТРАНСКАПИТАЛ ББСБ" ХХК | 75.0% | |
| 66 | "НАНОКАПИТАЛ ББСБ" ХХК | 73.6% | 18 |
| 67 | "НОМИН ЮНИТИ ББСБ" ХХК | 73.6% | |
| 68 | "МОНГОЛЫН САНХҮҮГИЙН ГРУПП ББСБ" ХХК | 63.9% | 19 |
| 69 | "ЭНТ КРЕДИТ ИНВЕСТМЕНТ ББСБ" ХХК | 61.1% | 20 |
| 70 | "ӨЛЗИЙТ ФИНАНС ББСБ" ХХК | 59.7% | 21 |
| 71 | "ТЭЛМЭН ХАС ББСБ" ХХК | 59.7% | |
| 72 | "ХААН КРЕДИТ ББСБ" ХХК | 56.9% | 22 |
| 73 | "ЦЭГЦ ХӨРӨНГӨ ББСБ" ХХК | 56.9% | |
| 74 | "ИНВЕСТОС ББСБ" ХХК | 55.6% | 23 |
| 75 | "ТИТЭМ КАПИТАЛ ББСБ" ХХК | 55.6% | |
| 76 | "ГОВЬ ФИНАНС ББСБ" ХХК | 54.2% | 24 |
| 77 | "ЦЕНТРАЛ КАПИТАЛ ББСБ" ХХК | 52.8% | 25 |
| 78 | "ГАЗАР КАПИТАЛ ПАРТНЕРС ББСБ" ХХК | 48.6% | 26 |
| 79 | "ГРИЙН ФИНТЕК ББСБ" ХХК | 40.3% | 27 |
| 80 | "ТЭНГЭРЛИГ АВТО ФИНАНС ББСБ" ХХК | 33.3% | 28 |
| 81 | "БИ ЭНД ЖИ ФИНАНС ББСБ" ХХК | 29.2% | 29 |
| 82 | "ДЭВЖИХ НЭХИЙ ББСБ" ХХК | 29.2% | |
| 83 | "БУМАН ДУСАЛ ББСБ" ХХК | 25.0% | 30 |

## 8. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН КОМПАНИУДЫН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ

*ДҮРСЛЭЛ 23. КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН АХИЦ ДЭВШИЛ:*




*Шигтгээ 16:*

*Нийт хөрөнгө оруулалтын менежментийн 18 компанийн кодексийн хэрэгжилтийн давтан үнэлгээ 23.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.*

*ДҮРСЛЭЛ 24. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН:*




*Шигтгээ 17:*

*Төлөөлөн удирдах зөвлөл нь 3 гишүүнтэйгээс 33.3% нь хараат бус гишүүд байна.*

*Шигтгээ 18:*

*Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний 37.5% нь эмэгтэй.*

*ДҮРСЛЭЛ 25. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:*




*ДҮРСЛЭЛ 26. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНААР АЖИЛЛАСАН АЖЛЫН ТУРШЛАГА (Жилээр):*




*ДҮРСЛЭЛ 27. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:*



*ДҮРСЛЭЛ 28. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН НАСЖИЛТ БА ЭЗЭМШСЭН МЭРГЭЖИЛ:*







*ДҮРСЛЭЛ 29. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД:*




*Шигтгээ 19:*

*Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод тус бүр дунджаар 2-3 гишүүнтэй.*

*ДҮРСЛЭЛ 30. ЦАХИМ ХУУДСАНД БАЙРШУУЛСАН ДОТООД ДҮРЭМ, ЖУРМЫН НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДЛЫН МЭДЭЭЛЭЛ:*




*Шигтгээ 20:*

*2024 оны байдлаар 12.0% нь компанийн дүрмээ өөрийн цахим хуудсандаа байршуулсан.*

*Шигтгээ 21:*

*Тайлант хугацаанд 36.0% нь дотоод дүрэм, журмаа нээлттэй болгосон.*

*ДҮРСЛЭЛ 31. САЙН БОЛОН МУУ ХЭРЭГЖСЭН КОДЕКСИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД:*



## 8.1. “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭГЭЭР БАЙР ЭЗЛҮҮЛСЭН ЗЭРЭГЛЭЛ (Давтан үнэлгээ ирүүлсэн компанийг ногооноор тодруулав)

| № | Компанийн нэрс | Үнэлгээ | Байр |
|---|---|---|---|
| 1 | "НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ УЛААНБААТАР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 97.2% | **1** |
| 2 | "АВАЛОН ИНВЕСТМЕНТС ҮЦК" ХХК | 94.4% | **2** |
| 3 | "АРД МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 94.4% | |
| 4 | "АШИД АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 94.4% | |
| 5 | "ДИ БИ ЭМ АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 93.1% | **3** |
| 6 | "ҮНЭТ АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 91.7% | **4** |
| 7 | "БАЛАНСЭД ГРӨҮТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 88.9% | **5** |
| 8 | "СИНЕРЖИ ФАНД СОЛЮШН ҮЦК" ХХК | 87.5% | **6** |
| 9 | "МАНДАЛ АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 86.1% | **7** |
| 10 | "СОД АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 83.3% | **8** |
| 11 | "ТЕН ИНВЕСТМЕНТ ҮЦК" ХХК | 83.3% | |
| 12 | "УЛААНБААТАР АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 81.9% | **9** |
| 13 | "ЭН ЖИ КОМИТИ ҮЦК" ХХК | 81.9% | |
| 14 | "ЮНИТИ АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 80.6% | **10** |
| 15 | "РАЙНОС ЭССЭТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 80.6% | |
| 16 | "ЭМ АЙ ДИ ЭЙ ЭС ҮЦК" ХХК | 80.6% | |
| 17 | "ИНВЕСКОР АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 79.2% | **11** |
| 18 | "ОКАНЕ ХОЛДИНГС ҮЦК" ХХК | 77.8% | **12** |
| 19 | "СТЭПП МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 75.0% | **13** |
| 20 | "ОЧУН ҮЦК" ХХК | 73.6% | **14** |
| 21 | "МАСТЕР ИНВЕСТМЕНТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 72.2% | **15** |
| 22 | "ИХ ЧИНГИС ХААНЫ ХӨМРӨГ ҮЦК" ХХК | 70.8% | **16** |
| 23 | "ТИ ДИ БИ АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 69.4% | **17** |
| 24 | "УАН ПАРТНЕРС ҮЦК" ХХК | 68.1% | **18** |
| 25 | "ҮҮРЭГ АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 65.3% | **19** |
| 26 | "БИ БИ ЭС ЭЙ ҮЦК" ХХК | 59.7% | **20** |
| 27 | "НЭЙШНЛ ФАНД МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 54.2% | **21** |
| 28 | "ЭКСПОНЭЙШНЛ ФАНД МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 45.8% | **22** |
| 29 | "БУМ АРД ИНВЕСТ ҮЦК" ХХК | 37.5% | **23** |
| 30 | "ЭРДЭНЭТ ВЕНЧУР АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 26.4% | **24** |
| 31 | "БАТ КАПИТАЛ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 23.6% | **25** |
| 32 | "НОВЕЛ АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 23.6% | |
| 33 | "ГОЛОМТ АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 20.8% | **26** |

## 9. ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧДИЙН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ

*ДҮРСЛЭЛ 32. КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН АХИЦ ДЭВШИЛ:*




*Шигтгээ 22:*

*Нийт виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч 9 компанийн кодексийн хэрэгжилтийн давтан үнэлгээ 6.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.*

*ДҮРСЛЭЛ 33. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН:*




*Шигтгээ 23:*

*Төлөөлөн удирдах зөвлөл нь 5-7 гишүүнтэйгээс 40.0% нь хараат бус гишүүд байна.*

*Шигтгээ 24:*

*Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний 30.0% нь эмэгтэй.*

*ДҮРСЛЭЛ 34. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:*




*ДҮРСЛЭЛ 35. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНААР АЖИЛЛАСАН АЖЛЫН ТУРШЛАГА (Жилээр):*




*ДҮРСЛЭЛ 36. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:*



*ДҮРСЛЭЛ 37. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН НАСЖИЛТ БА ЭЗЭМШСЭН МЭРГЭЖИЛ:*







*ДҮРСЛЭЛ 38. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД:*




*Шигтгээ 25:*

*Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод тус бүр дунджаар* ***2-3*** *гишүүнтэй.*

*ДҮРСЛЭЛ 39. ЦАХИМ ХУУДСАНД БАЙРШУУЛСАН ДОТООД ДҮРЭМ, ЖУРМЫН НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДЛЫН МЭДЭЭЛЭЛ:*




*Шигтгээ 26:*

*2024 оны байдлаар **11.0%** нь компанийн дүрмээ өөрийн цахим хуудсандаа байршуулсан.*

*Шигтгээ 27:*

*Тайлант хугацаанд **66.0%** нь дотоод дүрэм, журмаа нээлттэй болгосон.*

*ДҮРСЛЭЛ 40. САЙН БОЛОН МУУ ХЭРЭГЖСЭН КОДЕКСИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД:*

| Хамгийн сайн хэрэгжсэн компанийн засаглалын үзүүлэлтүүд: | | Хамгийн сул хэрэгжсэн компанийн засаглалын үзүүлэлтүүд: | |
|---|---|---|---|
| 98% | ТУЗ-ийн үйл ажиллагаа түүний эрх, үүрэг, хариуцлагын журам | 45% | ТУЗ-ийн болон түүний дэргэдэх хороодын үйл ажиллагааны тайлан |
| 94% | Эрх бүхий албан тушаалтныг нэр дэвшүүлэх зохицуулалт | 44% | ТУЗ-ийн гишүүдэд зориулсан чиглүүлэх болон чадваржуулах сургалт |
| 92% | Шүгэл үлээх тогтолцоо | 38% | Цахим хуудасны шинэчлэлт |
| 89% | Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх зохицуулалт | 0% | ТУЗ-ийн дарга, гишүүдийн ажлын үнэлгээ |

## 9.1. “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭГЭЭР БАЙР ЭЗЛҮҮЛСЭН ЗЭРЭГЛЭЛ (Давтан үнэлгээ ирүүлсэн компанийг ногооноор тодруулав)

| № | Компанийн нэрс | Үнэлгээ | Байр |
|---|---|---|---|
| 1 | "ДИЖИТАЛ ЭКСЧЕЙНЖ МОНГОЛИА" ХХК | 97.2% | **1** |
| 2 | "АНД ДЭНӨҮД" ХХК | 93.1% | **2** |
| 3 | "ИКС МЕТА" ХХК | 91.7% | **3** |
| 4 | "КОЙН ХАБ" ХХК | 87.5% | **4** |
| 5 | "ПОВЕРЭД ЭЙ ДИ ЭМ" ХХК | 87.5% | |
| 6 | "АЙДАКС" ХХК | 83.3% | **5** |
| 7 | "КОМПЛЕКС ДИЖИТАЛ ЭКОСИСТЕМ" ХХК | 80.6% | **6** |
| 8 | "ЧОЙЖИН АЛТЕКС" ХХК | 79.2% | **7** |
| 9 | "ЗООС ДИЖИТАЛ ЭКСЧЭЙНЖ" ХХК | 75.0% | **8** |
| 10 | "КАПЕКС КАПИТАЛ" ХХК | 56.9% | **9** |
| 11 | "НЭЙШНАЛ ТРЭЙШИР БИТ СЕКЬЮРИТИ" ХХК | 50.0% | **10** |
| 12 | "КОРЕКС" ХХК | 31.9% | **11** |

**-oOo-**